



Анхааруулга: Бүх холбоосууд дахь мэдээлэл нь зөвхөн англи хэл дээр байдаг.

ЗУСЛАНГИЙН МЭРГЭЖИЛТНҮҮДЭД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА – ТА ДЭЛХИЙН ХААНА Ч БАЙСАН АШИГЛАХ БОЛОМЖТОЙ

Америкийн зуслангуудын холбоо Мэргэжил дээшлүүлэх төв Зайн сургалт

МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ТӨВИЙН ТАЛААР ТАНЫ МЭДВЭЛ ЗОХИХ 5 ЧУХАЛ ЗҮЙЛ:

1. *Найдвартай.* Төвийн үйл ажиллагаа нь хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудалтай холбоотой зайлшгүй эзэмшвэл зохих 13 ур чадварт тулгуурласан тул сурч мэдсэн зүйл тань таны ирээдүйн ажил мэргэжилд чухал ач холбогдолтой юм. Америкийн зуслангуудын холбооны хөтөлбөрийн хүрээнд Та хамгийн чанартай мэдлэг, чадварыг эзэмших болно.

2. *Багц цаг.* Та сургалтанд хамрагдсанаар тасралтгүй сургалтын багц цагтай болно. Багц цаг буюу кредит цуглуулж, өөрийн амжилтаа баталгаажуулахаас гадна одоогийн болон цаашид хийх ажил мэргэжлийнхээ шаардлагыг бүрэн хангаж байгаагаа нотлон харуулж чадна.

3. *Үргэлж тантай хамт.* Та өөрөө төлөвлөж, зайн сургалтаар болон хурал зөвлөгөөн, сургалтын арга хэмжээнд биечлэн оролцох замаар суралцана. Зохион байгуулагдах арга хэмжээний төлөвлөгөө, зайн сургалтад хамрагдах боломжийн талаарх сургалтын танилцуулгаас шинэ мэдээлэл авах боломжтой.

4. *Боломжийн өртөг.* Таны халаасыг дундлахад бус, танд хэрэгтэй мэдлэг боловсролыг олгоход бидний зорилго оршино. Америкийн зуслангуудын холбооны гишүүн нь тус холбооны дэлгүүрээр борлуулагдаж буй 500 гаруй ном, DVD-нээс худалдан авах, мэргэжлийн ур чадвараа нэмэгдүүлэх талаар хөнгөлөлт эдэлнэ.

5. *Та өөрөө эзэн.* Манлайлал, эрсдэлийн удирдлага, эрүүл мэнд, аюулгүй байдал, маркетингийн чиглэлээр ур чадвар эзэмшихийг эрмэлзэж байгаа бол хамгийн зөв сонголт бол Америкийн зуслангуудын холбооны Боловсролын төв. Мэргэжил дээшлүүлэх төвд танд хэрэгтэй бүх зүйл бий. Тө өөрөө сонголтоо хийж, ажил хэрэг болгох л хэрэгтэй.

СУРГАЛТ, ВЭБЭД СУУРИЛСАН СЕМИНАР

Америкийн зуслангуудын холбооны зайн сургалт, вэбэд суурилсан семинар нь зуслан, сургууль, хичээлийн дараах хөтөлбөр, засгийн газрын хөтөлбөр, зуны болон хичээлээс гадуурх сургалтын байгууллагад ажиллагсдад тохиромжтой / [Check out the catalog of educational offerings/](#)

Хөтөлбөрийн ажилтнуудад зориулсан гэрчилгээ олгох сургалт

Америкийн зуслангуудын холбооны гэрчилгээ олгох зайн сургалтууд: [Certificates of Added Qualification](#).

Бүлгээр сургалтад хамрагдах бол сургалтын төлбөрийн талаар Америкийн зуслангуудын холбоотой дараах хаягаар холбогдоно: PDC@ACAacamps.org

- Анхан шатны — 15 кредит, 15 цаг, гишүүд тус бүр 15 ам.доллар
- Хөтөлбөрийн ажилтнуудад зориулсан- 15 кредит, 15 цаг, гишүүд тус бүр 15 ам.доллар
- Удирдах ажилтны-15 кредит, 15 цаг, гишүүд тус бүр 75 ам.доллар
- Зуслангийн дарга нарын-20 кредит, 20 цаг, гишүүд тус бүр 100 ам.доллар

Сургалт, вэбэд суурилсан семинарын багц

Багц сургалтуудаас сонголтоо хийж, өөрийн багцыг бүрдүүлнэ. Нэг буюу хэд хэдэн суралцагчийг сонгох боломжтой.

- Зайн сургалтын багц— Суралцагчдын тооноос хамаарч нэг кредит нь 1,50-5,00 ам.доллар. 3- аас дээш сургалт сонгоно.
- Зуслангийн ажилтнуудад зориулсан багц— 5 кредит, 5 цаг. 50 хүртэл суралцагчтай байх бөгөөд гишүүн бүрийн төлбөр нь 225 ам.доллар хүртэл байна.
- Зуслангийн хөтөлбөрийн захирал нарт зориулсан багц— 6.25 цаг, 6.25 кредит. 50 хүртэл суралцагчтай байх бөгөөд гишүүн бүрийн төлбөр нь 225 ам.доллар хүртэл байна.

e-CampFlix сургалтын видео материал

Сард 24,99 ам.долларын төлбөртэйгээр сургалтын видео материалыг хязгааргүй ашиглах эрхтэй. Видео материалын санг бүлгээр ашиглахад нэн тохиромжтой.

Америкийн зуслангуудын холбооны бусад ашиглах материал

[e-Books, Books, Forms, and Training DVDs](#)

[Camping Magazine](#) and [CampLine](#)

[Job Center](#)— ажлын байрны зар байршуулах, мэдээлэл авах

[U.S. Colleges and Universities Directory](#)

[Research Storehouse](#)

[Camp Knowledge Center](#)

Өөртөө болон ажилтнууддаа хөрөнгө оруулалт хийцгээе.

Ирээдүйдээ хөрөнгө оруулцгаая.

Тодруулах зүйл байвал цахим шуудан, утас болон скайпаар бидэнтэй холбогдоорой:
www.ACAacamps.org, 800-428-2267, PDC@ACAacamps.org

ЧҮЛТЭМ БЯМБАСҮРЭН

МОНГОЛЫН ЗУСЛАНГУУДЫН ХОЛБОО